# “ТӨРИЙН БАНК” ХК

# “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Өөрийн үнэлгээ/

Улаанбаатар 2023 он

## 1. Ерөнхий мэдээлэл

1.1. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолын хавсралтаар шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс” болон Монголын Хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2022 оны А/58 дугаар тушаалын дагуу “Компанийн засаглалын кодексийг үнэлэх аргачлал”-ын дагуу “Төрийн банк” ХК-ийн засаглалын өөрийн үнэлгээг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар гүйцэтгэн танилцуулж байна.

1.2. Төрийн банк” ХК-ийн засаглалын өөрийн үнэлгээг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн зүгээс хянан баталгаажуулсны дараа үнэлгээний үр дүнд өөрчлөлт орох магадлалтай.

## 2. Үнэлгээний зорилго

2.1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.

2.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг “Төрийн банк”-ны Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн дэргэдэх Засаглалын албанаас уг кодексийн нэгдүгээр хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.

2.3. Монголын Хөрөнгийн биржийн үнэт цаас гаргагч хариуцсан мэргэжилтэн нь “Төрийн банк” ХК-ийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн хяналтын оноо болон хувь бүхий үнэлгээний нэгдсэн дүнг жилд 1-ээс доошгүй удаа тооцно.

2.4. Үнэлгээний нэгдсэн дүнг Монголын Хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилалд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй хувьцаат компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.

2.5. Монголын Хөрөнгийн биржийн зүгээс “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, үнэлгээний нэгдсэн дүнг улирал тутмын эхний долоо хоногт Хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээллэнэ.

## 3. Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээ нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

| № | Гарчиг | Авбал зохих нийт оноо |
|---|---|---|
| 1 | ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт | 12 |
| 2 | ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг | 10 |
| 3 | Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал | 6 |
| 4 | Аудит, хяналтын тогтолцоо | 6 |

| | | |
|---|---|---|
| 5 | Эрсдэлийн удирдлага | 8 |
| 6 | Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал | 6 |
| 7 | Оролцогч талуудын эрх ашиг | 8 |
| 8 | Компанийн соёл | 6 |
| 9 | Хувьцаа эзэмшигчдийн эрх | 10 |
| **Нэгдсэн дүн** | | **72** |

## 4. Үнэлгээний аргачлал

4.1.Асуулга тус бүрийн хувьд хэрэгжилтийг 0-2 оноогоор үнэлж, хувьд шилжүүлэн үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргасан болно. Үүнд:

- Бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2 оноо;
- Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1 оноо;
- Үнэлгээ ирүүлээгүй бол 0 оноо.

4.2.Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн "Төрийн банк" ХК-ийн "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

- Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзнэ.

### "ТӨРИЙН БАНК" ХК-ИЙН "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НЭГДСЭН ДҮН

| № | Гарчиг | Авбал зохих нийт оноо | Үнэлсэн оноо | Хяналтын оноо | Үнэлгээний хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт | 12 | 11 | | 91.6% |
| 2 | ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг | 10 | 10 | | 90% |
| 3 | Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал | 6 | 6 | | 100% |
| 4 | Аудит, хяналтын тогтолцоо | 6 | 6 | | 100% |
| 5 | Эрсдэлийн удирдлага | 8 | 8 | | 100% |
| 6 | Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал | 6 | 6 | | 100% |
| 7 | Оролцогч талуудын эрх ашиг | 8 | 8 | | 100% |
| 8 | Компанийн соёл | 6 | 6 | | 100% |
| 9 | Хувьцаа эзэмшигчдийн эрх | 10 | 10 | | 100% |
| **Нэгдсэн дүн** | | **72** | **71** | | **99.06%** |

"Төрийн банк" ХК-ийн "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийн нэгдсэн дүн **99.06**% буюу ***<u>засаглал хэвийн буюу эрсдэлгүй</u>*** үнэлгээтэй байна.

# “ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ҮНЭЛГЭЭ

| НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна** | | | | | |
| **Д/д** | **Заалт** | **Хэрэгжилт** | **Тайлбар** | **Оноо** | **Хувь** |
| *1* | ***1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.*** | "Төрийн банк" ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05 дугаар тогтоолын хавсралтаар ТУЗ-ийн ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмаар ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, ТУЗ-ийн дарга, гишүүн, хараат бус гишүүний үүрэг, ТУЗ-ийн хурлын үйл ажиллагаа, ТУЗ-ийн үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах харилцаа, ТУЗ-ийн гишүүний баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоохтой холбогдох харилцаа нарийвчлан зохицуулсан. ТУЗ-ийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 15 дугаар тогтоолын хавсралтаар "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 3 дугаар зүйлд ТУЗ-ийн нарийн бичгийн даргын чиг үүрэг, 4 дүгээр зүйлд хариуцлагыг тус тус зохицуулсан байдаг. ТУЗ-ийн 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 28 дугаар тогтоолын хавсралтаар ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албаны ажиллах журмыг баталж, Засаглалын алба нь Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, “Төрийн банк” ХК-ийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”, Монголбанкнаас баталсан “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам”, банкны зохистой засаглалын бодлогыг хэрэгжүүлэх, банкны ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны зохион байгуулалт, банкны үйл ажиллагааны тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг хангуулах, ТУЗ-ийн гишүүдийн идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгагдсан. Шинэчлэн батлагдсан дээрх журмуудад Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст заасаны дагуу ТУЗ-ийн дарга, гишүүн болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Засаглалын албаны эрх, үүргийг тодорхойлон тусгаж, ТУЗ-ийн хурлыг зохион байгуулах, хэлэлцэх асуудлыг тогтоох, хурлын дэг зэрэг асуудлыг нарийвчлан тусгасан. */"Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, холбогдох журмуудыг хавсралтаар хүргүүлсэн болно./* | | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *2* | ***1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.*** | "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлд ТУЗ, 11 дүгээр зүйлд ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх журам, томилох, эрх, үүргийн талаарх зохицуулалтыг тусгасан. Тухайлбал: Дүрмийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт "Банкны ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 нь ердийн, 3 нь хараат бус гишүүн байна" гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт "Төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн Банкны ТУЗ-ийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлөх ТУЗ-ийн ердийн гишүүний нэрийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хадгаламжийн даатгалын Корпораци ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд санал болгох бөгөөд Нэр дэвшүүлэх хороо тухайн нэр дэвшигдэж байгаа этгээд нь холбогдох хууль болон энэхүү дүрэмд заасан шаардлага хангасан бол ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилуулах саналаа хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд оруулна" гэж, 11.2 дахь хэсэгт "Төрийг төлөөлөх ТУЗ-ийн ердийн гишүүд нь Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллөөс бүрдэнэ" гэж, 11.3 дахь хэсэгт "ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь Компанийн тухай хууль болон Банкны тухай хууль, Монголбанкны “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-д заасан шалгуурыг хангасан этгээдийг ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмын дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилуулахаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлнэ" гэж тус тус заасан.<br>Төрийн банк" ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05 дугаар тогтоолоор ТУЗ-ийн ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт "ТУЗ-ийг хууль тогтоомж болон банкны дүрэмд заасны дагуу байгуулах бөгөөд банкны дүрэмд заасан ердийн болон хараат бус гишүүдээс бүрдэнэ" гэж тусгасан.<br>Түүнчлэн, ТУЗ-ийн 2013 оны 79 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Төрийн банкны хүний нөөцийн бодлогоор Төрийн банкны хүний нөөцийн залгамж, халааны бодлогыг тодорхойлж байна. Тус бодлогод хүний нөөцийн бүрдүүлэлт, хүний нөөцийн сонголт, карьер хөгжлийн төлөвлөлт, хүний нөөцийн сургалт, хөгжүүлэлт, гүйцэтгэлийн удирдлага зэрэг асуудлыг зохицуулж байна. */"Төрийн банк" ХК-ийн дүрэм болон Төрийн банкны хүний нөөцийн бодлогийг хавсралтаар хүргүүлсэн болно./* | "Төрийн банк" ХК-ийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааны бодлогыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан зарчмуудын дагуу боловсруулсан бөгөөд "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар хүлээгдэж байна. Шинээр боловсруулж буй бодлогын төсөлд "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн гишүүнийг Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Монголбанкны “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан нөхцөл журмын дагуу сонгон шалгаруулж томилох тухай тусгасан.<br>*/"Төрийн банк" ХК-ийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааны бодлогын төслийг хавсралтаар хүргүүлсэн болно./* | 1 | 50% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *3* | ***1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.*** | ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааны тайланг Хувьцаа эзэмшигчдийн хурал болон эрх бүхий байгууллагуудаас тогтоосон дүрэм, журмын дагуу зохих хугацаанд тайлагнаж хэвшсэн бөгөөд тус тайланд ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл, ТУЗ-ийн зүгээс авч хэрэгжүүлэн ажилласан үйл ажиллагаа, ТУЗ-ийн хурал болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлын тоо, хэлэлцсэн асуудал, тогтоол шийдвэр, гишүүдийн хуралдаанд оролцсон ирцийн мэдээллүүдийг тусган тайлагнадаг. ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланг 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, "Төрийн банк" ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай 01 дүгээр тогтоолын төслийг хэлэлцүүлэн батлуулж ажилласан. Түүнчлэн, ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн хурлын талаарх мэдээллийг "Төрийн банк" ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланд тусган, банкны цахим хуудас болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулсан болно.<br>https://www.statebank.mn/product/1492<br>https://www.statebank.mn/product/1477<br>https://www.mse.mn/mn/company/564 | | 2 | 100% |
| *4* | ***1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах*** | "Төрийн банк" ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05 дугаар тогтоолын хавсралтаар ТУЗ-ийн ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмаар ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, ТУЗ-ийн дарга, гишүүн, хараат бус гишүүний үүрэг, ТУЗ-ийн хурлын үйл ажиллагаа, ТУЗ-ийн үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах харилцаа, ТУЗ-ийн гишүүний баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоохтой холбогдох харилцаа нарийвчлан зохицуулсан.<br>ТУЗ-ийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 13 дугаар тогтоолын хавсралтаар "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 2 дугаар зүйлд хороодын бүрэлдэхүүн, түүнд тавигдах шаардлага, хүйсийн тэнцвэр, 3 дугаар зүйлд хороодын эрхлэх чиглэл, хэлэлцэн шийдвэрлэх асуудал, 4 дүгээр зүйлд хороодын үйл ажиллагааны хэлбэр, хариуцлагыг тус тус зохицуулсан болно.<br>ТУЗ-ийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 14 дүгээр тогтоолын хавсралтаар ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг баталсан болно. */"Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмыг хавсралтаар хүргүүлсэн болно./* | | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ***шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.*** | | | | |
| 5 | ***1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.*** | "Төрийн банк" ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05 дугаар тогтоолын хавсралтаар ТУЗ-ийн ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмаар ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, ТУЗ-ийн дарга, гишүүн, хараат бус гишүүний үүрэг, ТУЗ-ийн хурлын үйл ажиллагаа, ТУЗ-ийн үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах харилцаа, ТУЗ-ийн гишүүний баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоохтой холбогдох харилцаа нарийвчлан зохицуулсан. Тус журамд заасны дагуу ТУЗ-ийн дарга гишүүд нь Банкны үйл ажиллагааны талаарх үнэн зөв мэдээлэл авах эрх, үүрэгтэйгээс гадна ТУЗ-ийн гишүүдийг банкны үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар гадаад, дотоодын хурал, семинарт оролцуулах, мэдээллээр хангах ажлыг ТУЗ-ийн дарга хариуцан зохион байгуулж шийдвэрлэхээр тусгасан. ТУЗ-ийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 15 дугаар тогтоолын хавсралтаар ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажиллах журмыг баталсан бөгөөд тус журамд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, чиглүүлэх шинэчлэх сургалтыг тогтмол хариуцан зохион байгуулахаар тусгасан. ТУЗ-ийн 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 28 дугаар тогтоолын хавсралтаар ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албаны ажиллах журмыг баталж, тус журмын 2 дугаар зүйлийн 2.1.15 дахь хэсэгт Засаглалын алба нь ТУЗ-ийн гишүүнийг чиглүүлэх сургалтыг зохион байгуулах, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад хамруулах саналыг ТУЗ-ийн даргад хүргүүлэх, ТУЗ-ийн гишүүдийг мэдээллээр хангах үүргийг тус тус хүлээн ажиллаж байгаа бөгөөд ТУЗ-ийн гишүүдэд зориулсан сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх төлөвлөгөөг батлан ажиллаж байна. Түүнчлэн, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаас банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх мэдээлэл бүхий гарын авлагыг ТУЗ-ийн шинэ гишүүдэд хүргүүлж ажилладаг. Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна" гэж заасны дагуу тус банкны ТУЗ-ийн бүх гишүүд холбогдох сургалтад хамрагдсан болно. */Сургалтын төлөвлөгөөг хавсаргав./* | "Төрийн банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 5 дугаар сарын 4-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 62 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд зориулсан сургалт, мэдээлэл өгөх ажлын төлөвлөгөөг баталсан бөгөөд төлөвлөгөөний 2.1, 2,2, 2,3, 2,4, 2.5, 2.6, 2.8 дахь хэсэгт заасан мэдээллийг тухай бүр Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын хуралд танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулан ажиллаж байна. | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *6* | ***1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.*** | "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 15 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажиллах журмын 2.1 дэх хэсэгт "ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг банкны ТУЗ-ийн даргын санал болгож, нэр дэвшүүлснээр ТУЗ-ийн нийт гишүүдийн дийлэнх олонхийн саналаар томилно" гэж, 2.3 дахь хэсэгт "ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай байгуулах хөдөлмөрийн гэрээнд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна" гэж, 3.1 дэх хэсэгт "ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хууль тогтоомжид зааснаас гадна Олон улсын хэмжээнд хэрэгжиж буй банкны зохистой засаглалын шинэ чиг хандлага, сайн туршлага, бодлогыг судлах, судалгааны үр дүнгийн талаар ТУЗ-д мэдээлэл хүргүүлэх, хэрэгжүүлэх арга зүйг судлан зөвлөмж хүргүүлэх, банкны талаарх мэдээлэл, тайлангуудыг холбогдох дүрэм журмын дагуу эрх бүхий байгууллагад хүргэж байгаа эсэх үйл ажиллагаанд улирал тутамд хяналт тавих, олон нийтэд ил болгох, банкны үйл ажиллагааны талаарх мэдээллийг хуульд заасан арга хэрэгслээр хүргэх, хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй хүргэх, банкны хувьцаа эзэмшигч, ТУЗ, түүний дэргэдэх хороод, гүйцэтгэх захирал, бусад газар, хэлтэс, алба, салбар, төлөөлөгчийн газар хоорондын мэдээлэл солилцооны үр дүнтэй байдлыг хангахад хувь нэмэр оруулж ажиллах, ХЭХ болон ТУЗ-ийн хурлыг банкны тухай хууль тогтоомж болон бусад хууль, тогтоомж, журам, дүрэм, зааврын хүрээнд хуралдуулах нөхцлийг хангах, ТУЗ-ийн хурлын товийг ТУЗ-ийн даргатай зөвшилцөн гаргаж, ТУЗ-ийн гишүүд, Дотоод аудитын газар, хуралд оролцох албан тушаалтнуудад мэдэгдэх, хурлыг зохион байгуулах, ХЭХ болон ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал, түүнд холбогдох мэдээлэл, баримт бичгүүд, хурлаас гаргах шийдвэрийн төслийг холбогдох албан тушаалтнаас гаргуулан авч хянах, ТУЗ-ын гишүүдэд мэдээлэл хүргэх, ТУЗ-ын хурлын дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөх, баталгаажуулах, ТУЗ-ийн хурлын үйл ажиллагаа, түүнд холбогдох дүрэм, журмын талаар зөвлөгөө өгөх, түүнд холбогдох оролцогчдын асуултад хариулах, ТУЗ-ийн хурлын явцад маргаан, үл ойлголцол үүсэхээс урьдчилан сэргийлэх, хурлын дэгийг сахиулах, маргаан, үл ойлгоцлыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авах, ХЭХ-ийн болон ТУЗ-ийн үйл ажиллагаанд холбогдох бичиг баримтыг хадгалах, эрх бүхий албан тушаалтны шаардлагаар танилцуулах, хадгалах хугацаа нь дууссан баримт бичгийг архивт шилжүүлэх, баримт бичгийн хуулбарыг зохих этгээдэд хүсэлтийн дагуу гаргаж өгөх, Банкны хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүдээс ирүүлсэн гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, бүртгэл хөтлөх, эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгч, хүлээн авсан этгээд уг гомдол, саналыг цаг хугацаанд нь барагдуулж, хариу өгч байгаа эсэхэд хяналт тавих" гэж тус тус тусгасан болно.<br>*/Холбогдох тайлан, журмыг хавсралтаар хүргүүлсэн болно./* | | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ** | | | | | |
| **Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ** | | | | | |
| 7 | ***2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.*** | "Төрийн банк" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот тогтоолоор батлагдсан "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлд "Төрийн банк" ХК-ийн ТУЗ нь нийт 9 гишүүнтэй ба түүний 3 нь хараат бус гишүүн байна гэж заасан. "Төрийн банк" ХК нь нэг бүр нь 250 (хоёр зуун тавь) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 755.096.250 (долоон зуун тавин таван сая ерэн зургаан мянга хоёр зуун тавь) ширхэг энгийн хувьцаатай буюу нийт 188.774.062.500 (нэг зуун наян найман тэрбум долоон зуун далан дөрвөн сая жаран хоёр мянга таван зуу) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд банкны нийт хувьцааны 372.000.000 (гурван зуун далан хоёр сая) ширхгийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 340,000,000 (гурван зуун дөчин сая) ширхгийг Хадгаламжийн даатгалын корпораци эзэмшиж, 43,096,250 (дөчин гурван сая ерэн зургаан мянга хоёр зуун тавь) ширхгийг нээлттэй зах зээлийн арилжаагаар худалдан авсан бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байгаа тул *төрийн өмчийн оролцооны хувь хэмжээг зохистой хэмжээнд хангах, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах* үүднээс Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийн 1/3-ийг хараат бус гишүүдээс бүрдүүлсэн болно.<br>Түүнчлэн, "Төрийн банк" ХК-ийн дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн дагуу хамгаалах, хувьцаа эзэмшигчдээс банкны үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдлыг хүлээн авч санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий Хяналтын зөвлөлтэй байх бөгөөд Хяналтын зөвлөл нь банкны тухай хуульд заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс бусад хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл бүхий 5 (тав) гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар тусган, Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 03 тоот тогтоолоор батлан ажиллаж байна.<br>"Төрийн банк" ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 дугаар тогтоолоор Төрийн банк нь 134,903,750 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд үе шаттайгаар нэмж гаргахыг зөвшөөрсөн бөгөөд нэмж гаргах энгийн хувьцааг Монголын хөрөнгийн бирж ХК-иар дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаалахаар тогтоосон бөгөөд хувьцааны хувь эзэмшилтэй холбогдуулан хараат бус гишүүдийн тоог хувьцаа эзэмшигчдийн хурлаас харгалзан тогтооно. */Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар хүргүүлэв./* | "Төрийн банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын мэдээллийг анкетийн дагуу боловсруулан хүргүүлэв. /Анкетийг хавсаргав./<br><br>"Төрийн банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын 2022 оны үйл ажиллагааны тайланг хавсралтаар хүргүүлэв. | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *8* | ***2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хурал компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.*** | "Төрийн банк" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот тогтоолоор батлагдсан "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 14 дүгээр зүйлд "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэд байнгын ажиллагаатай Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо ажиллахаар тогтоож, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэхээр тусгасан. "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 13 дугаар тогтоолоор "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 2 дугаар зүйлд Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүн, түүнд тавигдах шаардлага, хүйсийн тэнцвэр, 3 дугаар зүйлд хороодын эрхлэх чиглэл, хэлэлцэн шийдвэрлэх асуудал, 4 дүгээр зүйлд хороодын үйл ажиллагааны хэлбэр, хариуцлага, аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцох зохицуулалтыг тусгасан. Түүнчлэн, "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 14 дүгээр тогтоолоор "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг баталж, Аудитын хорооны даргаар тус банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнийг томилсон байна. Банкны аудитын бодлогыг ТУЗ-ийн 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 44 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар "Төрийн банк" ХК-ийн дотоод аудитын дүрмийг шинэчлэн баталж, тогтоосон бөгөөд тус дүрмээр ТУЗ-ийн Дотоод аудитын зорилго, зарчим, хамрах хүрээ, зохион байгуулалт, аудиторын баримтлах ёс зүйн зарчим, дотоод аудитын ажилтны эрх, үүрэг, болон аудиторын эрх, үүргийг тодорхойлж, дотоод аудитын үйл ажиллагааг явуулах, хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтран ажиллах харилцааг зохицуулж байна. "Төрийн банк" ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05 дугаар тогтоолын хавсралтаар ТУЗ-ийн ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 5 дугаар зүйлийн 5.2.1 дэх хэсэгт ТУЗ-ийн хараат бус гишүүн нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороодыг тэргүүлэн, идэвх санаачилгатай ажиллах үүргийг хүлээх тухай тусгаж өгсөн. */Холбогдох дүрэм, журам, тогтоолыг хавсралтаар хүргүүлсэн болно./* | | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *9* | ***2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.*** | "Төрийн банк" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот тогтоолоор батлагдсан "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 14 дүгээр зүйлд "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэд байнгын ажиллагаатай Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо байхаар тогтоож, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэхээр тусгасан. "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 13 дугаар тогтоолоор "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 2 дугаар зүйлд Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүн, түүнд тавигдах шаардлага, хүйсийн тэнцвэр, 3 дугаар зүйлд хороодын эрхлэх чиглэл, хэлэлцэн шийдвэрлэх асуудал,4 дүгээр зүйлд хороодын үйл ажиллагааны хэлбэр, хариуцлага, хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцох зохицуулалтыг тусгасан.<br>Түүнчлэн, "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 14 дүгээр тогтоолоор "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг баталж, Цалин урамшууллын хорооны даргаар тус банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнийг томилсон байна.<br>Банкны цалин урамшууллын бодлогын асуудлыг ТУЗ-ийн 2013 оны 79 тоот тогтоолоор батлагдсан "Төрийн банкны хүний нөөцийн бодлого"-оор тогтоосон бөгөөд бодлогын баримт бичгийн 10 дугаар зүйлээр банкны цалин хөлс, урамшуулал, нийгмийн халамжийн бодлогыг тодорхойлж байна."Төрийн банк" ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05 дугаар тогтоолын хавсралтаар ТУЗ-ийн ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 5 дугаар зүйлийн 5.2.1 дэх хэсэгт ТУЗ-ийн хараат бус гишүүн нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороодыг тэргүүлэн, идэвх санаачилгатай ажиллах үүргийг хүлээх тухай тусгаж өгсөн. */Холбогдох дүрэм, журам, тогтоолыг хавсралтаар хүргүүлсэн болно./* | | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *10* | ***2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.*** | Төрийн банкны ТУЗ-ийн 2013 оны 79 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн банкны хүний нөөцийн бодлого"-оор Төрийн банкны хүний нөөцийн залгамж, халааны бодлогыг тодорхойлж байна. Тус бодлогод хүний нөөцийн бүрдүүлэлт, хүний нөөцийн сонголт, карьер хөгжлийн төлөвлөлт, хүний нөөцийн сургалт, хөгжүүлэлт, гүйцэтгэлийн удирдлага зэрэг асуудлыг зохицуулж байна. "Төрийн банк" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот тогтоолоор батлагдсан "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 14 дүгээр зүйлд "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэд байнгын ажиллагаатай Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо байхаар тогтоож, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэхээр, "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 13 дугаар тогтоолоор "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 2 дугаар зүйлд Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүн, түүнд тавигдах шаардлага, хүйсийн тэнцвэр, 3 дугаар зүйлд хороодын эрхлэх чиглэл, хэлэлцэн шийдвэрлэх асуудал, 4 дүгээр зүйлд хороодын үйл ажиллагааны хэлбэр, хариуцлага, хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцох зохицуулалтыг тус тус тусгаж, "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 14 дүгээр тогтоолоор "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг баталж, Нэр дэвшүүлэх хорооны даргаар тус банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнийг томилсон байна. Түүнчлэн, "Төрийн банк" ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05 дугаар тогтоолын хавсралтаар ТУЗ-ийн ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 5 дугаар зүйлийн 5.2.1 дэх хэсэгт ТУЗ-ийн хараат бус гишүүн нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороодыг тэргүүлэн, идэвх санаачилгатай ажиллах үүргийг хүлээх тухай тусгаж өгсөн. */Холбогдох журмыг хавсралтаар хүргүүлсэн болно./* | "Төрийн банк" ХК-ийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааны бодлогыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан зарчмуудын дагуу боловсруулсан бөгөөд "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар хүлээгдэж байна. Шинээр боловсруулж буй бодлогын төсөлд "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн гишүүнийг Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Монголбанкны “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан нөхцөл журмын дагуу сонгон шалгаруулж томилох тухай тусгасан. */"Төрийн банк" ХК-ийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааны бодлогын төслийг хавсралтаар хүргүүлсэн болно./* | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *11* | ***2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.*** | "Төрийн банк" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот тогтоолоор батлагдсан "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "14.4. ТУЗ шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороо байгуулан ажиллуулж болно" гэж, "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын ... тоот тогтоолоор батлагдсан "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмын 1.3 дахь хэсэгт "ТУЗ нь цаг үеийн шинжтэй болон шаардлагатай асуудлаар бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болох бөгөөд ийнхүү байгуулсан хорооны үйл ажиллагааны чиглэл, хэлэлцэх асуудал болон хороог даргалах гишүүнийг томилох асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ" гэж тус тус заасан. Түүнчлэн, "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмын 3.1-д Эрсдэлийн удирдлагын хороотой байхаар тогтоосон бөгөөд тус хороо нь Банкны үйл ажиллагааны нэгж тус бүрд үүсэж болох эрсдэлийн түвшинг тодорхойлох, илрүүлэх, эрсдэлийг бууруулах, арилгахад шаардлагатай арга хэмжээг авах зэргээр эрсдэлийн оновчтой, шуурхай, хараат бус удирдлагыг хэрэгжүүлэх, Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хянах тогтолцоог бүрдүүлэх, банкны зохистой, чадварлаг, мэргэшсэн эрсдэлийн удирдлага, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх эрсдэлийг үнэлэх, банкны үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлийг удирдах чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ. "Төрийн банк" ХК-ийн Эрсдэл хариуцсан нэгжээс Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны тайланг улирал бүр ЭУХ-нд тогтмол тайлагнадаг бөгөөд хорооноос эрсдэл бууруулах чиглэлээр холбогдох үүрэг даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавин ажиллаж хэвшээд байна. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо болон Нэр дэвшүүлэх хороог ТУЗ-ийн хараат бус гишүүн, Монгол Улсын гавьяат эдийн засагч нар тэргүүлэн ажиллаж байгаа бөгөөд хороодын бүрэлдэхүүнд санхүү, эдийн засаг, аудит, эрсдэлийн удирдлын чиглэлээр мэргэшсэн гишүүд ажиллаж байна. ТУЗ-ийн гишүүдийн анкетийг хавсарган хүргүүлэв. | | 2 | 100% |
| **ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ** | | | | | |
| **Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *12* | ***3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг батална, хэрэгжилтэд нь хяналт тавина.*** | "Төрийн банк" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот тогтоолоор батлагдсан "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.13.13 дахь заалтад ТУЗ нь "Банкны зохистой засаглалын бодлого, журмыг тогтоож хэрэгжилтэд хяналт тавих" гэж, 10.13.35 дахь заалтад "Банкны тухай хуульд заасан санхүүгийн тайлан, бусад мэдээллийг нийтэд мэдээлэх явцад хяналт тавих" гэж тус тус заасны дагуу банкны хэмжээнд мөрдөгдөж буй дүрэм, журмын хүрээнд банкны үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг олон нийт болон эрх бүхий байгууллагад тогтоосон хугацаанд болон шаардсан тухай бүр гарган мэдээлж байгаа бөгөөд хувьцаа эзэмшигч этгээд банкны үйл ажиллагаатай холбогдох мэдээлэл, тайланг тухай бүр гаргуулан авах эрхтэй болно.<br>"Төрийн банк" ХК нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох эрх бүхий байгууллагууд, зохицуулах байгууллагаас батлан гаргасан дүрэм, журам, банкны ТУЗ, гүйцэтгэх захирлаас баталсан дүрэм, журам, заавар бодлогын хүрээнд ил тод байдлын тайлагналыг хэрэгжүүлэн ажилладаг. Хувьцаа эзэмшигчид болон Банкны эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, Дотоод хяналтын тогтолцоо, Засаглалын тогтолцоо, Санхүүгийн тайлангийн тайлагнал, Хэлцэл, Банкны бүтээгдхүүн үйлчилгээ, Нийгмийн хариуцлага зэрэг мэдээллүүдийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргүүлдэг.<br>Түүнчлэн, "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолын хавсралтаар Хувьцаа эзэмшигч, олон нийтэд "Төрийн банк" ХК-ийн мэдээллийг ил тод мэдээлэх, тайлагнах журмыг баталж, тус журмаар банкны үйл ажиллагааны талаарх мэдээллийг банкны хувьцаа эзэмшигч, олон нийтэд мэдээллэх, тайлагнах, мэдээллийн төрөл, хэлбэрийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж, хэрэгжилтэд ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албанаар дамжуулан ТУЗ хяналт тавьж ажиллаж байна. */Холбогдох журмыг хавсралтаар хүргүүлэв./* | | 2 | 100% |
| *13* | ***3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.*** | "Төрийн банк" ХК нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох эрх бүхий байгууллагууд, зохицуулах байгууллагаас батлан гаргасан дүрэм, журам, банкны ТУЗ, гүйцэтгэх захирлаас баталсан дүрэм, журам, заавар бодлогын дагуу ил тод байдлын тайлагналын хүрээнд холбогдох мэдээ мэдээллийг Банкны цахим хуудас /statebank.mn/-д байршуулан ил тод байдлын тайлагналыг хэрэгжүүлэн ажилладаг.<br>Хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон Банкны эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, Дотоод хяналтын тогтолцоо, Засаглалын тогтолцоо, Санхүүгийн тайлангийн тайлагнал, Хэлцэлийн талаар толилуулах, Банкны бүтээгдхүүн үйлчилгээг мэдээлэх, Нийгмийн хариуцлага зэрэг мэдээллүүдийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл | "Төрийн банк" ХК-ийн засаглалын баримт бичиг, дүрэм журам, зааврыг банкны цахим хуудаст байршуулав. /https://www.statebank.mn/product/1500/ | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хүргүүлдэг.<br>"Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 26 дугаар тогтоолын хавсралтаар Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг батлан, ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албанаас хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн ТУЗ тогтмол хяналт тавин ажиллаж байна.<br>Түүнчлэн, "Төрийн банк" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын 02 дугаар тогтоолын хавсралтаар "Төрийн банк" хувьцаат компанийн дүрэм, 03 дугаар тогтоолын хавсралтаар "Төрийн банк" ХК-ийн хяналтын зөвлөлийн ажиллах журам, 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын 04 дүгээр тогтоолын хавсралтаар "Төрийн банк" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын журам, 05 дугаар тогтоолын хавсралтаар "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн ажиллах журам, "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 45 дугаар тогтоолын хавсралтаар Төрийн банкны зохистой засаглалын журам, 2020 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар Төрийн банкны комплаенсийн бодлого, 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 57 дугаар тогтоолын хавсралтаар Ногдол ашгийн бодлого, 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар Төрийн банкны ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журам, 15 дугаар тогтоолын хавсралтаар "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажиллах журам, 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 23 дугаар тогтоолын хавсралтаар "Төрийн банк" ХК-ийн сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих журам, 24 дүгээр тогтоолын хавсралтаар Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого, 25 дугаар тогтоолын хавсралтаар Хувьцаа эзэмшигч, олон нийтэд "Төрийн банк" ХК-ийн мэдээллийг ил тод мэдээлэх, тайлагнах журам, 28 дугаар тогтоолын хавсралтаар ТУЗ-ийн дэргэдэх засаглалын албаны ажиллах журам, 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 44 дүгээр тогтоолын хавсралтаар "Төрийн банк" ХК-ийн дотоод аудитын дүрэм зэргийг тус тус батлан мөрдүүлж ажиллаж байна.<br>"Төрийн банк" ХК-ийн цахим хуудсанд Компанийн засаглалын кодексийн хэрэгжилттэй уялдуулан зарим нэмэлт цэсийг хөгжүүлж, Хувьцаа эзэмшигч, олон нийтэд мэдээлэл хүргэн ажиллаж байна.<br>https://www.statebank.mn/product/1500<br>https://www.statebank.mn/product/1056<br>https://www.statebank.mn/product/285<br>*/Хөтөлбөрийг хавсралтаар хүргүүлэв./* | | | |
| *14* | ***3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй,*** | Банкны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт заасны дагуу НББОУС, СТОУС, Монголбанкны “Нягтлан бодох бүртгэлийн багц материал”, Төрийн банкны “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-т нийцүүлэн Монголбанкнаас тогтоосон нягтлан бодох бүртгэлийн зарчимд нийцүүлж, банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх | | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ***тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.*** | удирдлага, холбогдох бусад эрх бүхий албан тушаалтан баталгаажуулан улирлын санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын дотор, аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон банкны цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлж байна. "Төрийн банк" ХК-ийн Бизнесийн төлөвлөгөөнд хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтуудыг тусгаж боловсруулан өмнөх оны 12 дугаар сард багтаан Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж ажилладаг бөгөөд Гүйцэтгэх захирлын 2018 оны А-260 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн банкны дунд хугацааны стратеги болон бизнес төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, хянах журам"-ын дагуу хэрэгжилтийг ханган төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудын биелэлтийг нэгтгэн авч банкны Дотоод аудитын газарт хүргүүлж, Дотоод аудитын газар биелэлтийг хянан шалгаж, дүгнэлт гарган үр дүнг тодорхойлж ажилладаг.<br>Түүнчлэн, Төрийн банкны үйл ажиллагааны жилийн тайланг хэвлэмэл хэлбэрээр болон банкны сайтад тогтмол оруулан нийтэд мэдээллийг хүргэн ажилладаг. Төрийн банкны цахим хуудасны САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ буланд банкны үйл ажиллагааны жилийн тайлан, санхүүгийн аудитлагдсан тайланг Монгол, Англи хэл дээр цаг тухай бүрд тогтмол оруулан олон нийтэд мэдээллийг хүргэн ажилладаг.<br>https://www.statebank.mn/product/505<br>https://www.statebank.mn/m/1049<br>"Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолын хавсралтаар Хувьцаа эзэмшигч, олон нийтэд "Төрийн банк" ХК-ийн мэдээллийг ил тод мэдээлэх, тайлагнах журмыг баталж, тус журмаар банкны үйл ажиллагааны талаарх мэдээллийг банкны хувьцаа эзэмшигч, олон нийтэд мэдээллэх, тайлагнах, мэдээллийн төрөл, хэлбэрийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж, хэрэгжилтэд ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албаар дамжуулан ТУЗ хяналт тавьж ажиллаж байна.<br>Түүнчлэн, "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 91 дүгээр тогтоолын хавсралтаар Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлогыг батлан, хэрэгжилтийг МХБ-д хүргүүлэн ажиллаж байгаа бөгөөд "Төрийн банк" ХК-ийн Бизнесийн бодлого, төлөвлөлтийн газрын харьяанд Тогтвортой хөгжлийн албыг 2023 оны 2 дугаар сард байгуулан ажиллаж эхлээд байна.<br>*/МХБ-д хүргүүлсэн БОНЗ-ын тайланг хавсаргав./* | | | |
| **ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО** | | | | | |
| **Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *15* | ***4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.*** | "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 13 дугаар тогтоолоор "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцүүлэн ТУЗ нь банкны аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангахад чиглэсэн агуулгаар шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт Аудитын хорооны чиг үүргийг банкны нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, ТУЗ-өөс баталсан банкны стратеги төлөвлөгөө, банкны бодлогын хэрэгжилт, банкны үндсэн үйл ажиллагааны явцад хийгдэх гүйцэтгэлийн болон санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох асуудал, түүний үнэн бодит байдалд хяналт тавих, банкны дотоод болон хөндлөнгийн аудитын цар хүрээг тодорхойлох, үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх, хөндлөнгийн болон дотоод аудит, комплайнсын хяналтын хараат бус байдлыг баталгаажуулах, хараат бус байдалд учирч болзошгүй эрсдэл, түүнийг хэрхэн удирдаж байгаа талаарх хэрэгжилтийн үр дүнг хангаж ажиллах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:<br>3.2.1. Банкны санхүүгийн жилийн тайланд хөндлөнгийн аудит хийх этгээдийг сонгон шалгаруулахад тавигдах шалгуур үзүүлэлт, эрх, үүрэг, төлөх хөлсний хэмжээг тогтоох болон гэрээний төслийг боловсруулах, хөндлөнгийн аудитын хараат бус байдалд учирч болзошгүй, эсхүл учирч буй эрсдэлд санал, дүгнэлт өгөх;<br>3.2.2. Банкны санхүүгийн жилийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын тайланг банкны ТУЗ-өөр хэлэлцэн шийдвэрлэхийн өмнө хөндлөнгийн аудиттай харилцан мэдээлэл солилцох, санал, дүгнэлт өгөх, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн аудитын гэрээг цуцлах санал гаргаж, ТУЗ-д танилцуулах;<br>3.2.3. Хөндлөнгийн аудитороос тухайн жилд банканд үзүүлж болох хуулиар тогтоосноос бусад үйлчилгээний төрөл, жагсаалтыг баталж, түүнд хяналт тавих.<br>Банкны аудитын бодлогыг ТУЗ-ийн 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 44 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар "Төрийн банк" ХК-ийн дотоод аудитын дүрмийг шинэчлэн баталж, тогтоосон бөгөөд тус дүрмээр ТУЗ-ийн Дотоод аудитын зорилго, зарчим, хамрах хүрээ, зохион байгуулалт, аудиторын баримтлах ёс зүйн зарчим, дотоод аудитын ажилтны эрх, үүрэг, болон аудиторын эрх, үүргийг тодорхойлж, дотоод аудитын үйл ажиллагааг явуулах, хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтран ажиллах харилцааг зохицуулж байна. */Холбогдох дүрэм, журмыг хавсралтаар хүргүүлсэн болно./* | | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *16* | ***4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.*** | "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 10.13.14 дэх хэсэгт заасны дагуу банкны ТУЗ нь Банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хамарсан зохистой хяналтын тогтолцоог бүрдүүлэх үүрэг хүлээж байгаа бөгөөд дүрмийн 18 дугаар бүлэгт "Хөндлөнгийн аудит"-ын талаарх харилцааг зохицуулсан тусгайлсан бүлгийг тусгаж, дүрмийн 19.10 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ нь банкны санхүүгийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэн, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах үүрэг хүлээсэн. Төрийн банк" ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05 дугаар тогтоолоор ТУЗ-ийн ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 2 дугаар зүйлийн 2.9, 5 дугаар зүйлийн 5.14.2 дахь заалт, "Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгнө." гэж тусгасан. */"Төрийн банк" ХК-ийн дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлын журмыг хавсралтаар хүргүүлсэн болно./* | | 2 | 100% |
| *17* | ***4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.*** | "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 44 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар "Төрийн банк" ХК-ийн дотоод аудитын дүрмийг шинэчлэн баталж, тус дүрмээр ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын зорилго, зарчим, хамрах хүрээ, зохион байгуулалт, аудиторын баримтлах ёс зүйн зарчим, дотоод аудитын ажилтны эрх, үүрэг, болон аудиторын эрх, үүргийг тодорхойлж, дотоод аудитын үйл ажиллагаag явуулах, хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтран ажиллах харилцааг зохицуулж байна.Дотоод аудитын газрын үйл ажиллагааны тайланг банкны жилийн үйл ажиллагааны тайланд тогтмол тусгаж, банкны цахим хуудсаар дамжуулах Дотоод аудитын газрын бүтэц, чиг, үүрэг, жилийн тайланг олон нийтэд мэдээллэн ажиллаж байна. */"Төрийн банк" ХК-ийн Дотоод аудитын дүрмийг хавсралтаар хүргүүлсэн болно./* | "Төрийн банк" ХК-ийн Дотоод аудитын тогтолцоо, Дотоод аудитын газрын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг шинэчлэн банкны цахим хуудсанд байршуулав. /https://www.statebank.mn/product/297 https://www.statebank.mn/product/288/ | 2 | 100% |
| **ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА** | | | | | |
| **Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *18* | ***5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.*** | "Төрийн банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны 80 тоот тогтоолын хавсралтаар Төрийн банкны Эрсдэлийн удирдлагын бодлого, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 63 тоот тогтоолын хавсралтаар Төийн банкны эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам, Гүйцэтгэх захирлын 2012 оны А/11 тоот тушаалын хавсралтаар Төрийн банкны мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний аргачлал, Гүйцэтгэх захирлын 2014 оны А/200 тоот тушаалын хавсралтаар Төрийн банкны зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын журам, Гүйцэтгэх захирлын 2014 оны А/520 тоот тушаалын хавсралтаар Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам, Гүйцэтгэх захирлын 2019 оны А/433 тоот тушаалын хавсралтаар Төрийн банкны дотоод ашиглан, залилангийн эрсдэлийн удирдлагын журам, Гүйцэтгэх захирлын 2020 оны А/286 тоот тушаалын хавсралтаар Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, хүлээгдэж буй алдагдлыг тооцох, активыг эрсдэлийн сангаас хорогдуулах үйл ажиллагааны журам, Гүйцэтгэх захирлын 2020 оны А/352 тоот тушаалын хавсралтаар Банкны нэгдсэн эрсдэлийг үнэлэх аргачлал батлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.<br>"Төрийн банк" ХК-ийн эрсдэлийн удирдлагны бодлогод эрсдэлийг удирдах зарчмыг тусгаж, гурван давхар хамгаалалтын шугам бүхий эрсдэлийн тогтолцоог хэрэгжүүлэх бөгөөд хамгаалалтын гуравдугаар шугам буюу Дотоод аудитын газар банкны эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдал, бодлогын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд сайжруулах арга хэмжээний өвлөмжийг өгч, Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнаж ажиллахаар тогтоосон. Түүнчлэн, Эрсдэлийн удирдлагын асуудал хариуцсан нэгж нь банкны нэгдсэн эрсдэлийн түвшинг эрсдэлийн үнэлгээний матрицаар тодорхойлж, өндөр болон хэт өндөр түвшинтэй эрсдэлийг тайланг нэгтгэж улирал бүр банкны эрсдэлтийн удирдлагын хороо болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хороонд танилцуулж, эрсдэлийн удирдлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайланг улирал бүр Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хороонд хүргүүлж ажиллаж байна.<br>https://www.statebank.mn/product/288<br>*/Холбогдох бодлого, журмуудыг хавсралтаар хүргүүлсэн болно./* | | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *19* | ***5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.*** | "Төрийн банк" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот тогтоолоор батлагдсан "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 14 дүгээр зүйлд "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэд байнгын ажиллагаатай Эрсдэлийн удирдлагын хороо байхаар тогтоож, хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэхээр тусгасан. "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 13 дугаар тогтоолоор "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 2 дугаар зүйлд Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүн, түүнд тавигдах шаардлага, хүйсийн тэнцвэр, 3 дугаар зүйлд хороодын эрхлэх чиглэл, хэлэлцэн шийдвэрлэх асуудал, 4 дүгээр зүйлд хороодын үйл ажиллагааны хэлбэр, хариуцлагыг тус тус зохицуулсан болно. Түүнчлэн, "Төрийн банк" ХК-ийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 14 дүгээр тогтоолоор "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг баталсан байна. */Холбогдох журам, тогтоолыг хавсралтаар хүргүүлсэн болно./* "Төрийн банк" ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05 дугаар тогтоолын хавсралтаар ТУЗ-ийн ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт "ТУЗ-ийн дэргэд байнгын ажиллагаатай Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороотой байна" 5 дугаар зүйлийн 5.2.7 дахь заалтад ТУЗ-ийн хараат бус гишүүн нь "Банкны санхүү болон санхүүгийн бус мэдээллийн бүрэн бүтэн байдал, санхүүгийн хяналт, эрсдэлийн менежментийн системийн талаар болон эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хязгаарыг тогтоохдоо хөндлөнгийн мэргэжлийн этгээд /банкны эрх бүхий албан тушаалтан болон зөвлөх үйлчилгээний үр дүн ашиг сонирхолд нь тодорхой хэмжээгээр нөлөөлж болзошгүй аливаа этгээдээс хараат бус байх этгээд/-ийн зөвлөгөөг банкны зардлаар эсхүл үнэ төлбөргүй авах" эрхтэй гэж тусгайлан заасан болно. | "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмын 3.1-д заасны дагуу тус хороо нь Банкны үйл ажиллагааны нэгж тус бүрд үүсэж болох эрсдэлийн түвшинг тодорхойлох, илрүүлэх, эрсдэлийг бууруулах, арилгахад шаардлагатай арга хэмжээг авах зэргээр эрсдэлийн оновчтой, шуурхай, хараат бус удирдлагыг хэрэгжүүлэх, Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хянах тогтолцоог бүрдүүлэх, банкны зохистой, чадварлаг, мэргэшсэн эрсдэлийн удирдлага, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх эрсдэлийг үнэлэх, банкны үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлийг удирдах чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх бөгөөд тус журмын 2.4 дэх заалтын дагуу ЭУХ-ны дарга, гишүүд нь санхүүгийн тайлагналын зохих мэдлэг, туршлагатай, банканд хөндлөнгийн аудит хийж байгаа компанитай аливаа ашиг сонирхлын холбоогүй, сүүлийн гурван жилийн хугацаанд тухайн компанид ажиллаж байгаагүй ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн байх, 2.1, 2.3 дахь заалтын дагуу тус хороо 3 гишүүний бүрэлдэхүүнтэй, хороодын бүрэлдэхүүний 2 буюу олонх нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байхаар тогтоосон. Түүнчлэн, тус журмын 2.8 дахь хэсэгт "Хороодын гишүүдийн танилцуулга, намтар, хорооны үйл ажиллагааны жилийн тайланг ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланд тусгаж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | танилцуулна" гэж, 4.15 дахь хэсэгт "Банкны жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд хороодын үйл ажиллагааны чиглэл, эрхэлсэн асуудалд холбогдох бодлогын баримт бичиг, бүтэц бүрэлдэхүүний мэдээлэл, хурлын давтамж, хэлэлцсэн асуудал, ирцийг нийтэд тогтмол мэдээлнэ" гэж тусгасан. */Холбогдох журам, тогтоолыг хавсралтаар хүргүүлсэн болно./* | | |
| *20* | ***5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.*** | "Төрийн банк" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн А/377 дугаар тушаалаар "Төрийн банкны байгаль орчин, нийгэм, жендерийн эрх тэгш байдлын бодлого, журам" батлагдсан бөгөөд тус журмын 10 дугаар зүйлд Байгаль орчин, нийгмийн хариуцлагын эрсдэлийн үнэлгээний тайлагналын асуудлыг тусгасан. "Монгол улсын тогтвортой санхүүжилтийн зарчмууд"-ыг хэрэгжүүлэх ажлын явц, амжилт, тулгарч буй бэрхшээл, хоёрдмол асуудлын тухай мэдээллийг холбогдох газар, хэлтсүүдээс нэгтгэн авч "ТоС-ийн Удирдах хороонд тайлагналын маягт"-ын дагуу жилд 2 удаа тайлан бэлтгэж хүргүүлж байгаа бөгөөд Зээлийн үйл ажиллагааны журмын холбогдох хавсралтад заасан "Зээлийн гүйлгээ хийхийн өмнөх шалгах хуудас"-т "Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийгдсэн эсэх", "Нэмэлт шаардлага биелэгдсэн эсэх", "Зээлийн гэрээнд тусгахаар шийдвэрлэсэн байгаль орчин, нийгэм, жендэрийн эрх тэгш байдлын талаар нэмэлт шаардлага тавигдсан эсэх" шаардлагыг нэмж тусган давхар хяналтыг сайжруулсан.<br>Зээл олгосны дараах хяналтыг сайжруулах зорилгоор хавсралт "Зээлийн хяналтын тайлан"-д "Байгаль орчин, нийгэм, жендэрийн эрх тэгш байдлын талаар нэмэлт шаардлага тавигдсан эсэх", "Нэмэлт шаардлагын биелэлт", "Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж буй эсэх" хэсгүүдийг нэмж, хяналтыг хэрэгжүүлж байна.<br>Зээлийн хяналтыг сайжруулах зорилгоор Нэгжийн захирал/Харилцааны ахлах менежер нь 50.0-80.0 сая төгрөгийн дүнтэй зээлийн "Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ" хийгдсэн эсэх болон үнэлгээний бодит байдалд хяналт тавьж ажиллах зохицуулалтыг мөрдөж ажиллаж байна. Зээлийн ажилтан эхлээд журмын хавсралтын дагуу Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийн түвшингээс хамаарч "Өндөр" эрсдэлтэй зээлийн материалыг Бизнесийн эрсдэлийн хэлтсийн мэргэжилтнээр хянуулж, шаардлагатай гэвэл мэргэжлийн газраар дүгнэлт гаргуулна.<br>"Төрийн банк" ХК-ийн 2022 оны 91 дүгээр тогтоолоор Төрийн банкны | | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгаль орчин, нийгэм засаглалын бодлогыг баталсан бөгөөд тус бодлогоор банкны бизнесийн болон дотоодын үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэм болон зохистой засаглалын талаар баримтлах зарчмыг тодорхойлох, үүсэх эрсдэлийг бууруулах, хянах, удирдах үйл ажиллагааг зохицуулж байна. Төрийн банкны байгаль орчин, нийгэм засаглалын бодлогод Байгаль орчны талаар баримтлах бодлого, Нийгмийн бодлогын хүрээнд баримтлах зарчим, Засаглалын бодлого, зарчмуудыг тусгаж, банкны Тогтвортой санхүүжилтын асуудал хариуцсан нэгж нь санхүүгийн тайлагналтай уялдуулан жилд нэг удаа бодлогын хэрэгжилтийг ТУЗ –ийн хуралд тайлагнах бөгөөд мэргэжлийн байгууллага эсхүл холбоодтой хамтран ажиллах замаар байгаль орчин, нийгэм засаглалтай холбоотой аливаа тайланг эх үүсвэр татах , энэ чиглэлийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олон улсын тайлагналын дагуу хийж гүйцэтгэж болох ба дотоод болон гадаадын аудитын байгууллагаар үнэлүүлж, дүгнэлт гаргуулж ажиллахаар тогтоосон. "Төрийн банк" ХК нь жил бүрийн үйл ажиллагааны тайландаа Компанийн засаглалын кодексийн 5.3-д заасан асуудлыг тогтмол тусган хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд хэвлэмэл хэлбэрээр болон цахим хэлбэрээр мэдээлж ажилладаг. Түүнчлэн, "Төрийн банк" ХК-ийн Бизнесийн бодлого, төлөвлөлтийн газрын харьяанд Тогтвортой хөгжлийн албыг 2023 оны 2 дугаар сард байгуулан ажиллаж, тайланг МХБ-д хүргүүлэн ажиллаж эхлээд байна. */МХБ-д хүргүүлсэн БОНЗ-ын тайланг хавсаргав./* | | | |
| *21* | ***5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.*** | Төрийн банк нь ТУЗ-ийн 2015 оны 34-р тогтоолоор Комплайнсийн асуудал хариуцсан нэгжийг банкны бүтцэд байгуулсан бөгөөд ТУЗ-ийн 2015 оны 62 дугаар тогтоолоор Комплайнсийн бодлогыг баталж, улмаар ТУЗ-ийн 2020 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар Комплайнсийн бодлогыг шинэчлэн баталсан. Комплайнсийн бодлогод тусгагдсан журмын дагуу Комплайнсийн асуудал хариуцсан нэгж нь банкны удирдлагаас хараат бус, бие даасан байдалтай ажилладаг бөгөөд банкны комплайнсийн үйл ажиллагаа, бодлого, журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг эрхлэн гүйцэтгэж, ТУЗ-д улирал бүр комплайнсийн хяналтын үр дүнгийн талаар тайлагнаж, ТУЗ-аас хяналтыг хэрэгжүүлж ажилладаг. */Комплайнсийн бодлогыг хавсралтаар хүргүүлсэн болно./* | | 2 | 100% |
| **ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ** | | | | | |
| **Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *22* | ***6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.*** | "Төрийн банк" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот тогтоолоор батлагдсан "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.15-д ТУЗ-ийн дарга, гишүүний цалин, урамшууллын хэмжээг тогтоох бүрэн эрхийг банкны хувьцаа эзэмшигчийн хурал хэрэгжүүлэхээр тусгагдсан, мөн дүрмийн 10.10 дахь хэсэгт ТУЗ-ийн гишүүнд урамшуулал олгож болох бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоохоор тусгагдсан байна.<br>"Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмыг 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр баталж, ТУЗ-ийн дэргэд Цалин урамшууллын хороо ажиллахаар тогтоосон. Тус журмын 3.4.2 дахь хэсэгт ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал, олгох хэлбэр, давтамжийг тогтоох саналыг Цалин урамшууллын хороо хэлэлцэн боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах үүрэг хүлээхээр тусгагдсан.<br>*/"Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журам болон"Төрийн банк" ХК-ийн дүрмийг хавсралтаар хүргүүлсэн болно./* | | 2 | 100% |
| *23* | ***6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.*** | "Төрийн банкны ТУЗ-ийн 2013 оны 79 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн банк" ХК-ийн "Хүний нөөцийн бодлого", Гүйцэтгэх захирлын 2013 оны А/424 тушаалаар батлагдсан “Ажилтны гүйцэтгэлийн үнэлгээний журам”-д цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг дараах байдлаар тусгасан. Үүнд:<br>Хүний нөөцийн бодлого:<br>9.3. Гүйцэтгэлийн үнэлгээ нь байнга хийгдэх удирдлагын үйл ажиллагаа бөгөөд ажилтны ажлын гүйцэтгэлийг жилд 4 удаа үнэлнэ.<br>9.5. Гүйцэтгэлийн үнэлгээ нь үнэлгээний хугацаанд ажилтны хийсэн ажил дээр тулгуурлан хийгдэх бөгөөд ур чадварын үнэлгээ, үүрэг хариуцлагын гүйцэтгэл болон тавьсан зорилгодоо хүрсэн эсэхийг хамруулан үнэлнэ.<br>10.2. Цалин хөлс, урамшууллын хэмжээ тухайн газар, хэлтэс, нэгж болон хувь хүний ажлын гүйцэтгэлд тулгуурласан байх ерөнхий зарчмыг баримтална.<br>10.3. Ажилтны цалин хөлсөнд нөлөөлөгч хүчин зүйлд хариуцлагын түвшин, мэргэшлийн ур чадвар, гүйцэтгэлийн үнэлгээ, идэвх зүтгэл ба ажлын хариуцлага, бүтээлч, шинэ санаа гаргаж нэвтрүүлсэн байдал болон тус банкны ашигт ажиллагаа хамаарна.<br>10.10. Банкны амжилтанд нөлөөлөхүйц хувь нэмэр оруулсан ажилчдыг шударгаар үнэлж шагнал, урамшууллыг олгох стратегийг баримтална.<br>Ажилтны гүйцэтгэлийн үнэлгээний журам:<br>2.2.1. Үнэлгээний хугацааны эхэнд болон ажилтны ажлын байр өөрчлөгдөх үед зорилгыг тодорхойлж, холбогдох ажилтнуудтай зөвшилцсөн байна.<br>2.2.4. Зорилго нь дараах үндсэн 2 төрөлд хуваагдана.<br>2.2.4.1. Бизнесийг дэмжих зорилго буюу тодорхой бизнесийн болон | | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | санхүүгийн үйл ажиллагаатай холбогдолтой зорилгууд. 2.2.4.2. Гүйцэтгэлийг дэмжих зорилго буюу гүйцэтгэлийг сайжруулах зорилгууд. | | | |
| *24* | ***6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.*** | Төрийн банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төрийн банк хувьцаат компанийн дүрэм болон ТУЗ-ийн 2016 оны 101 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн банкны гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх, урамшуулал олгох журам"-д гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг дараах байдлаар тусгасан. Үүнд: *Төрийн банкны дүрмийн* 15.4-т Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд гүйцэтгэх захирлын ажлын зорилт, зорилго, ажил үүргийн хуваарь, хугацаа, санхүүгийн болон үйл ажиллагааны хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, эрх, үүрэг, хүлээлгэх хариуцлага, цалин, урамшууллын хэмжээ, түүний эрх хэмжээг түдгэлзүүлэх, чөлөөлөх үндэслэл, үйл ажиллагааны тайлан, мэдээ гаргах хуваарь, ажлын гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт хангагдсан тохиолдолд гэрээг сунгах талаар тусгасан байна. Төрийн банкны гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх, урамшуулал олгох журамд Гүйцэтгэх удирдлага нь жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор өмнө жилийн гэрээний биелэлтийг гаргаж ТУЗ-д ирүүлэх ба гэрээний биелэлт, ажлын үр дүнг багцалсан шалгуур, зорилтот түвшингийн үзүүлэлтийн биелэлтэд үндэслэн үнэлгээ өгөх бөгөөд үнэлгээний шалгуур үзүүлэлтийг баталсан. "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмын 3.4.3 дахь заалтын дагуу Банкны гүйцэтгэх захирал, бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын дээд хязгаарыг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо тогтоохоор тусгасан. "Төрийн банк" ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллын талаарх мэдээллийг тусган, нийтэлсэн болно. https://shareholder.statebank.mn/<br>- https://heyzine.com/flip-book/7848d01987.html#page/12 | | 2 | 100% |
| **ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ** | | | | | |
| **Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 25 | ***7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.*** | "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 24 дүгээр тогтоолын хавсралтаар Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого, 25 дугаар тогтоолын хавсралтаар Хувьцаа эзэмшигч, олон нийтэд "Төрийн банк" ХК-ийн мэдээллийг ил тод мэдээлэх, тайлагнах журмыг тус тус батлсан. Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичгээр оролцогч талууд болон ирээдүйн хөрөнгө оруулагч, санхүүгийн зах зээлд оролцогч этгээдэд банкны үйл ажиллагааны мэдээлэл, стратегийн зорилтын хэрэгжилт, засаглал, хэтийн төлөв, санхүүгийн гүйцэтгэл, үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц үйл явдлын талаарх мэдээллийг хүргэж, хамтран ажиллах бодлогыг тодорхойлж, Хувьцаа эзэмшигч, олон нийтэд "Төрийн банк" ХК-ийн мэдээллийг ил тод мэдээлэх, тайлагнах журмаар банкны үйл ажиллагааны талаарх мэдээллийг банкны хувьцаа эзэмшигч, олон нийтэд мэдээллэх, тайлагнах, мэдээллийн төрөл, хэлбэрийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж, хэрэгжилтэд ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албаар дамжуулан ТУЗ хяналт тавьж ажиллаж байна. | | 2 | 100% |
| 26 | ***7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж*** | Банкны жилийн үйл ажиллагааны тайланд банкны 3 жилийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан стратегийг баримтлан оролцогч талуудтай хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаарх тайланг тусган тайлагнадаг. Оролцогч талуудтай хамтран ажилласан талаар "Төрийн банк" ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланд тусгасан болно. https://shareholder.statebank.mn/<br>- https://heyzine.com/flip-book/7848d01987.html#page/12 | | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ***ажилласан талаар тусгана.*** | | | | |
| *27* | ***7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.*** | "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолын хавсралтаар Хувьцаа эзэмшигч, олон нийтэд "Төрийн банк" ХК-ийн мэдээллийг ил тод мэдээлэх, тайлагнах журмыг баталж, тус журмаар банкны үйл ажиллагааны талаарх мэдээллийг банкны хувьцаа эзэмшигч, олон нийтэд мэдээллэх, тайлагнах, мэдээллийн төрөл, хэлбэрийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж, хэрэгжилтэд ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албанаар дамжуулан ТУЗ хяналт тавьж ажиллаж байна.<br>Тус журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт "Тухай бүр нийтэд нээлттэй болгох мэдээлэлд дор дурдсан мэдээллийг тооцох бөгөөд банкны цахим хуудас болон шаардлагатай тохиолдолд Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд нээлттэй мэдээлнэ" гэж, 3.6 дахь хэсэгт "Банк өөрийн цахим хуудсыг оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, ажиллагаанд үр дүнтэйгээр ашиглана" гэж, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт "ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын алба нь банкны цахим хуудсанд “Компанийн засаглалын кодекс”-т заасан бодлогын баримт бичгүүд, дотоод дүрэм, журмыг байршуулж, цаг тухайд нь шинэчлэн хувьцаа эзэмшигч, бусад оролцогч талуудыг мэдээллээр хангана" гэж, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт "Дотоод мэдээллийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасан журмын дагуу цахим хуудас, эсхүл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тухайн этгээдэд саадгүй хүргэх боломжийг хангасан бусад хэлбэрээр нийтэд мэдээлж, ил болгоно" гэж тус тус тусгасан болно.<br>Төрийн банкны цахим хуудас /statebank.mn/ болон Statebank of Mongolia фэйсбүүк хуудсанд банкны үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг тогтмол оруулан ажиллаж байна. Тус цахим хуудасны чатаар ирсэн харилцагчийн санал гомдолд мэдээлэл өгч ажилладаг.<br>Мөн банкны цахим хуудсанд банкны бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулга мэдээлэл, бүтээгдэхүүний хүү шимтгэл, нөхцлийг тогтмол шинэчлэн ажилладаг.<br>https://www.statebank.mn/page/1<br>https://www.facebook.com/StatebankMN | | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *28* | ***7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.*** | "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 94 дүгээр тогтоолоор баталсан Нийгмийн хөгжлийн сангийн зарцуулалтын журам, 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Оролцогч талуудтай хамтран ажиллах бодлого, Гүйцэтгэх захирлын 2013 оны А/271 тушаалаар батлагдсан Ажилтнаас гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай журам, 2013 оны А/255 дугаар тушаалаар баталсан Сургалтын журам, 2019 оны А/345 дугаар тушаалаар баталсан Ажилтны орон сууцны зээлийн журам, Сургалтын журмуудад ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх зэрэг асуудлыг дараах байдлаар тусгасан. Үүнд:<br>Нийгмийн хөгжлийн сангийн зарцуулалтын журам:<br>1.2. Төрийн банкны Нийгмийн хөгжлийн санг Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогын хүрээнд ажилтнуудад хөнгөлөлт тусламж үзүүлэх, тэтгэмж, урамшуулал олгох, тэдний идэвхжүүлэх зорилгоор ашиглана.<br>1.3 Банкны НХС-г зарцуулахдаа нийт ажилтнуудад эрх тэгш, хүртээмжтэй байлгах зарчмыг баримтална.<br>Ажилтнаас гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай журам<br>Сургалтын журам:<br>Журмын зорилго нь Төрийн банкны дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг биелүүлэхэд ажилтнуудад дэмжлэг үзүүлэн, тэдний мэдлэг, чадвар, хандлагыг сайжруулах, системтэйгээр сургаж хөгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулна. Сургалт нь Мэргэшүүлэх сургалт, Суурь сургалт, Ахисан түвшний сургалт, Чадваржуулах сургалт, Мэргэжлийн зэрэг ахиулах сургалт, Дотоодод зэрэг ахиулах сургалт, Гадаад улсад зэрэг ахиулах болон нарийн мэргэшлийн диплом, сертификат олгох сургалт, Хөгжүүлэх сургалт чиглэлтэй байна.<br>Ажилтны орон сууцны зээлийн журам:<br>Төрийн банкны Ажилтны орон сууцны зээлийн журам нь ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах болон зээл хүсэгчид орон сууцны зээлийг олгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулна. Орон сууцны зээлд хамрагдах ажилтанд тавигдах ерөнхий шаардлага, орон сууцны зээлийн нөхцөл, жилд хуваарилах орон сууцны зээлийн эрхийн хэмжээ зэрэг асуудлыг тусгасан.<br>Ажилтнаас гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай журам:<br>Төрийн банкны ажилтнаас байгууллагын удирдлагад хандаж гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Ажилтнаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэхдээ энэ журам болон Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх | | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг удирдлага болгоно.<br>Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого: Ажилтныг банкны үйл ажиллагааг хэрэгжүүлэгч гэдэг утгаар нь түүнтэй харилцахдаа хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан эрх хэмжээ, үүрэг, хариуцлагын хүрээнд харилцах бөгөөд Хөдөлмөрийн дотоод журамд ажилтны эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх зохицуулалтыг тусгах ба хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөтэй байна, ажилтны гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ ажилтанд аль болохуйц ашигтай байдлаар хууль тогтоомжид нийцүүлэн шийдэх талаар зааж өгсөн. */Холбогдох журмыг хавсаргав./* | | | |
| **НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ** | | | | | |
| **Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно** | | | | | |
| *29* | ***8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.*** | "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 41 дүгээр тогтоолын хавсралтаар "Төрийн банк" ХК-ийн "Ажилтны ёс зүйн дүрэм"-ийг баталсан бөгөөд тус дүрмээр банкны зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, банкны үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргэх үйл ажиллагаанд баримтлах зарчим, мөрдөх ёс зүйн хэм хэмжээг тодорхойлж, хэвшүүлэх, зөрчигдөхөөс сэргийлэх болон ёс зүйн зөрчилтэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулж байна. Тус дүрэмд ёс зүйн дүрмийн үйлчлэх хүрээ, ёс зүйн зарчим, ёс зүйн эрхэмлэн дээдлэх зүйлс, ажилтанд хориглох ёс зүйн хэм хэмжээ, ёс зүйн зөрчлийг мэдээлэх, шийдвэрлэх зэрэг асуудлыг тусгасан бөгөөд дүрмийн хэрэгжилтийг ТУЗ-д тогтмол тайлагнаж хэвшээд байна. Түүнчлэн, "Төрийн банк" ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05 дугаар тогтоолын хавсралтаар ТУЗ-ийн ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 8 дугаар зүйлд ТУЗ-ийн гишүүний баримтлах ёс зүйн хэм хэмжээг тусгайлан баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *30* | ***8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.*** | Төрийн банкны Комплайнсийн бодлого, Комплайнсийн үйл ажиллагааны журамд заасны дагуу "Шүгэл үлээх" үйл ажиллагааг хэрэгжүүлж, шүгэл үлээх тогтолцоог бүрдүүлсэн. Нийт ажилтнуудад зориулсан “Шүгэл үлээх” үйл ажиллагаа, хэрхэн шүгэл үлээх талаарх гарын авлагыг боловсруулж, дотоод мэдээллийн программд ажилтнуудын “Шүгэл үлээх” буланг байршуулж мэдээллийг хүргүүлсэн. Банкны ажилтан, харилцагчдаас шүгэл үлээх тохиолдолд мэдээллийг хүлээн авах, мэдээллийн нууцлалын хангах, хараат бусаар түргэн шуурхай хүлээн авах сувгийг боловсронгуй болгож Төрийн банкны вэб сайтанд “Шүгэл үлээх” буланг байршуулсан. Шүгэл үлээх үйл ажиллагаа түүнтэй холбоотой хийгдсэн ажил, авсан арга хэмжээний талаар улирал бүр ТУЗ-д тайлагнадаг. "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 13 дугаар тогтоолоор "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 3 дугаар зүйл буюу Нэр дэвшүүлэх хорооны хэрэгжүүлэх чиг үүрэгт "Банкны үйл ажиллагаанд гарч буй хууль бус үйлдэл, ёс зүйн зөрчлийн талаар мэдээлэх “шүгэл үлээгч”-ийн талаарх бодлогыг банкны ТУЗ-өөр хэлэлцэн батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн батлахын өмнө шаардлагатай санал, дүгнэлт өгч, хэрэгжилт, үр дүнд хяналт тавих, сургалт зохион байгуулах, “шүгэл үлээгч”-ийн мэдээллийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан хүлээн авч, тухай бүр хэлэлцэн шийдвэрлэх, шаардлагатай нөхцөлд ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх" тухай тусгагдсан.<br>Түүнчлэн, "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан "Ажилтны ёс зүйн дүрэм"-ийн 6.4 дэх хэсэгт "Ажилтан нь ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдал үүсэх үед тухайн ажлаас татгалзах, бусдын ёс зүйн зөрчлийг мэдсэн бол шүгэл үлээж, зөрчлийн талаар холбогдох албан тушаалтан, нэгжид мэдээлэх, гэмт хэргийн шинжтэй бол хууль сахиулах байгууллагад мэдэгдэх зэрэг үүрэгтэй" гэж заасан бөгөөд ажилтан Шүгэл үлээхдээ зөрчлийг таслан зогсоох талаар зөрчил гаргагчид өөрт нь анхааруулах, ажилтны өөрийнх нь гүйцэтгэх ажилтай холбоотойгоор ямар нэг ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал үүсвэл энэ тухай шууд удирдлагад танилцуулж татгалзах, зөрчлийн талаар холбогдох албан тушаалтан, зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах нэгж, холбогдох Хороонд мэдээлж, Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнаж ажиллах талаар тусгасан байна. */"Төрийн банк" ХК-ийн Ёс зүйн дүрэм, гарын авлагыг хавсралтаар хүргүүлсэн болно./* | | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 31 | ***8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.*** | "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 41 дүгээр тогтоолын хавсралтаар "Төрийн банк" ХК-ийн "Ажилтны ёс зүйн дүрэм"-д авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаарх харилцааг дараах байдлаар тусгасан. Үүнд:<br>1. Ажилтан нь Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;<br>2. Ажилтан нь Авлига, хээл хахуулиас ангид байх:<br>- Хувийн ашиг сонирхлоо нийтийн ашиг сонирхлоос дээгүүрт тавих, бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын нөлөөнд автах, ашиг сонирхлын зөрчил үүсгэх нөхцөл байдал үүсгэхийг,<br>- Бусдад авилга, хахууль өгөх, өгөхөөр амлах, зуучлах, бусдаас шаардахыг,<br>- Ажилтан болон эрх бүхий албан тушаалтан хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ үл мэдүүлэхийг,<br>- Ажил үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу хяналт тавих ажилд хамаарал бүхий этгээд, нэгдмэл сохирхолтой этгээдтэй хамт ажиллах, үл мэдээлэх, улмаар түүнийг албан тушаалд дэвшүүлэх, дотоод, гадаадын сургалтад сонгохыг,<br>- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлд заасан хязгаараас хэтэрсэн хүүг харилцагчдад амлах зэргээр санхүүгийн харилцаанд орохыг,<br>- Банкны үйлчилгээ үзүүлж ханшийн болон хүүний зөрүүг бусдаас шаардах, хувьдаа авах зэргээр санхүүгийн харилцаанд орохыг,<br>- Албан үүргээ биелүүлсэн болон биелүүлээгүйн төлөө өөрөө эсхүл хамаарал бүхий этгээдээр дамжуулан бусдаас төлбөр, бэлэг, зээл, өв хөрөнгө, хандив, урамшуулал, хөнгөлөлттэй үйлчилгээ авах зэрэг хууль бус бусад хангамж эдлэхийг,<br>- Ажилтан нь бусдад хүүтэй мөнгө зээлэх зэргээр хувийн үйлчилгээ үзүүлэхийг,<br>- Зээл олгох, гэрээ байгуулах, тендерт оролцож байгаа байгууллага, иргэн аж ахуй нэгжид давуу байдал үүсгэхээр урьдчилан үгсэн тохиролцох, амлалт өгөх, бэлэг, хандив тусламж авах,<br>- Хууль бусаар орлого олох, татвараас зайлсхийх гэх зэрэг.<br>3. Улс төрийн, шашны зэрэг үйл ажиллагаанд Банкыг төлөөлж оролцох. | | 2 | 100% |
| **ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ** | | | | | |
| **Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх боломцоогоор бүрэн хангана** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *32* | ***9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.*** | Банкны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, бүтэц зохион байгуулалт, хувьцаа эзэмжигчдийн хувь хэмжээ, улирал, жилийн санхүүгийн тайлан, мэдээ мэдээллийг банкны цахим хуудсанд тогтмол байршуулдаг. https://www.statebank.mn/product/285 https://www.statebank.mn/product/1056 https://www.statebank.mn/product/505 https://www.statebank.mn/product/553 | "Төрийн банк" ХХК нь "Төрийн банк" ХК болж хэлбэрээ өөрчилсөн тул "Төрийн банк" ХК-ийн Оролцогч талуудтай харилцах, мэдээлэл хүргэх журмыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан зарчмуудын дагуу шинээр боловсруулж, "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 3 дугаар сарын хурлаар хэлэлцэн батлахаар төлөвлөн ажиллаж байна. */"Төрийн банк" ХК-ийн Оролцогч талуудтай харилцах, мэдээлэл хүргэх журмыг хавсралтаар хүргүүлсэн болно./* | 2 | 100% |
| *33* | ***9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.*** | "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 24 дүгээр тогтоолын хавсралтаар Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого, 25 дугаар тогтоолын хавсралтаар Хувьцаа эзэмшигч, олон нийтэд "Төрийн банк" ХК-ийн мэдээллийг ил тод мэдээлэх, тайлагнах журмыг тус тус баталсан. Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичгээр оролцогч талууд болон ирээдүйн хөрөнгө оруулагч, санхүүгийн зах зээлд оролцогч этгээдэд банкны үйл ажиллагааны мэдээлэл, стратегийн зорилтын хэрэгжилт, засаглал, хэтийн төлөв, санхүүгийн гүйцэтгэл, үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц үйл явдлын талаарх мэдээллийг хүргэж, хамтран ажиллах бодлогыг тодорхойлж, Хувьцаа эзэмшигч, олон нийтэд "Төрийн банк" ХК-ийн мэдээллийг ил тод мэдээлэх, тайлагнах журмаар банкны үйл ажиллагааны талаарх мэдээллийг банкны хувьцаа эзэмшигч, олон нийтэд мэдээллэх, тайлагнах, мэдээллийн төрөл, хэлбэрийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж, хэрэгжилтэд ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албаар дамжуулан ТУЗ хяналт тавьж ажиллаж байна.<br>"Төрийн банк" ХК-ийн https://shareholder.statebank.mn/ цахим хаяг, sbm_shareholder@statebank.mn цахим шуудан, суурин холбооны 1800-1881 дугаарын утас, Statebank of Mongolia фэйсбүүк хуудас болон https://www.statebank.mn/ цахим хаягт олон нийттэй харилцах чат сувгийг хөгжүүлж, хөрөнгө оруулагчдаас ирсэн санал хүсэлт, гомдолд хариу | | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хүргүүлж ажилладаг. Түүнчлэн, "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд худалдах үндсэн чиглэл батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар "Төрийн өмчит банкны хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-ийг батлагдсан бөгөөд тус үндсэн чиглэлийг хөрөнгө оруулагчтай харилцахад баримтлан ажиллаж байна. Төрийн өмчит банкны хувьцааг олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх үндсэн чиглэлийн зорилго нь Банкны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн өмчит банкийг нэмж хувьцаа гарган биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангахад оршино гэж тодорхойлсон. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтлахаар тогтоосон болно. Үүнд:<br>1. Төрийн өмчит банкийг олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгох замаар ил тод байдлыг хангаж, санхүүгийн сахилга батыг сайжруулж, олон нийтийн хяналтад оруулах;<br>2. Банкны үйл ажиллагааны тасралтгүй, хэвийн байдлыг хангаж харилцагч, хадгаламж эзэмшигчдийн хууль ёсны эрх ашгийг бүрэн хамгаалах;<br>3. Зах зээл дэх төрийн оролцоог багасгаж, зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих;<br>4. Төрийн өмчит банкны хувьцааг биржээр худалдах үйл ажиллагааг хууль, эрх зүйн хүрээнд ил тод, нээлттэй хэрэгжүүлэх гэж тус тус заасан байна. | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *34* | ***9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.*** | "Төрийн банк" ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 04 дүгээр тогтоолын хавсралтаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмаар хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, хуралд оролцох эрх, хурлын зар хүргэх, хэлэлцэх асуудалтай танилцах, хэлэлцэх асуудалд санал оруулах, тооллогын комисс, ирц, саналын хуудас, эчнээ санал хураалт, хурлын тэмдэглэл, гомдол гаргах, хувьцаа эзэмшигчдэд хүргэх мэдээлэл, хурлын дэг, хариуцлага, ил тод байдал зэрэг асуудлыг зохицуулж байна. Тус журамд Компанийн засаглалын кодекст заасан хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлсэн.<br>"Төрийн банк" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсэгт "Хувьцаа эзэмшигчдийн хуралд банкны нийт саналын эрх бүхий хувьцааны 50 (тавь) ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно" гэж, 8.10 дахь хэсэгт "ХЭХ-ын бэлтгэл хангахад банкны эрх бүхий албан тушаалтан дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээ, мэдээллээр шуурхай хангах үүрэг хүлээнэ" гэж, 8.14 хэсэгт "Хувьцаа эзэмшигчдийн хурлыг Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас батлан гаргасан хүчин төгөлдөр бүхий эрх зүйн баримт бичигт заасны дагуу зохион байгуулна" гэж тусгасан.<br>Төрийн банк ХК-ийн дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн дагуу хамгаалах, хувьцаа эзэмшигчдээс банкны үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдлыг хүлээн авч санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий Хяналтын зөвлөлтэй байх бөгөөд Хяналтын зөвлөл нь банкны тухай хуульд заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс бусад хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл бүхий 5 (тав) гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар тусган, Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 03 тоот тогтоолоор батлан ажиллаж байна. | ***Судалгаанд зориулж нэмэлт мэдээлэл:***<br>*"Төрийн банк" ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт "ХЭХ-ийг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулж болно" гэж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын журмын 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэгт "ХЭХ-ыг танхим, цахим болон хосолсон (цахим, танхим) хэлбэрээр зохион байгуулж болно" гэж, 2.6 дахь хэсэгт "ХЭХ-ыг цахим болон хосолсон хэлбэрээр зохион байгуулахдаа Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Хувьцаат компанийн ХЭХ-ын зар хүргэх журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байна" гэж тус тус зааж өгсөн бөгөөд Төрийн банкны зүгээс хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах, санал хураалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн "shareholder.statebank.mn" цахим системийг хөгжүүлэн 2022 оны 12 дугаар сарын 10, 2023 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд тус тус ашигласан.* | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 35 | ***9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.*** | "Төрийн банк" ХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 04 дүгээр тогтоолын хавсралтаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 5 дугаар зүйлийн 5.16, 5.17 дахь хэсэгт банкны өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудалд холбогдох нэмэлт мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх талаар тусгайлан тусгасан.<br>"Төрийн банк" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт Банкны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлах, нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах, банкны хэлбэрийг өөрчлөх, банкны өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох, банкийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох, хувьцааг хуваах буюу нэгтгэх, давуу эрхийн хувьцаа гаргах, хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батлах тухай тусгасан. | ***<u>Судалгаанд зориулж нэмэлт мэдээлэл:</u>***<br>*"Төрийн банк" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын журмын 5 дугаар зүйлийн 5.16 дахь хэсэгт "Хурлаар банкны хувьцааг эргүүлэн худалдаж авах шаардлага тавих эрхтэй холбогдсон асуудлыг хөндөх бол ХЭХ-ын бэлтгэл ажлын явцад ХЭХ-д оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд тараах нэмэлт мэдээлэл буюу материалд дараах зүйлүүдийг оруулна:*<br>*5.16.1.Хувьцаа эзэмшигч хувьцааг эргүүлэн худалдан авах шаардлагыг эрхийнхээ дагуу тавих үеийн тухайн хувьцааны зах зээлийн үнийн талаар хөндлөнгийн үнэлгээчний дүгнэлт;*<br>*5.16.2.Тайлангийн хугацааны банкны хөрөнгийн цэвэр үнэлгээний тооцоо;*<br>*5.16.3.Хувьцааг эргүүлэн худалдан авах тухай болон эргүүлэн худалдан авах үнийн талаар шийдвэр гаргасан ТУЗ-ийн хурлын тэмдэглэл /эсвэл холбогдох хэсэг/;*<br>*5.16.4.Шаардлагатай бусад мэдээлэл" гэж тусгайлан заасан бөгөөд түүнд холбогдох бусад асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна.* | 2 | 100% |
| 36 | ***9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний*** | Төрийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 58 дугаар тогтоолын хавсралтаар Сонирхлын зөрчлийг зохицуулах журмыг баталж, 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 23 дугаар тогтоолын хавсралтаар тус журмыг шинэчлэн "Төрийн банк" ХК-ийн сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих журам баталсан бөгөөд тус журмаар нэгдмэл сонирхолтой этгээд, түүнтэй хийх хэлцлийг тодорхойлох, банкны үйл ажиллагаан дахь сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэхэй холбогдсон харилцааг зохицуулж байна.<br>"Төрийн банк" ХК-ийн сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих журамд нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлж бүртгэх, Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд, түүний хүлээх үүрэг, хэлцэл хийх журам, Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэг, гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, журмын хэрэгжилтэд хяналт тавих зэрэг асуудлыг тусгасан бөгөөд | "Төрийн банк ХК-ийн сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих журам"-д заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээ, тайланг банкны Комплайнсийн хяналтын чиг үүрэг хариуцсан нэгж сар бүр гарган, Гүйцэтгэх захирлаар баталгаажуулан дараа сарын 03-ны өдрийн дотор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглалын албанд хүргүүлж хэвшсэн бөгөөд тухайн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнд холбогдох хөндлөнгийн аудитын | 2 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ***хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.*** | сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг Төлөөлөн удирдах зөвлөлийн жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж, олон нийтэд мэдээллэн ажиллаж байна. | дүгнэлтийн Төлөөлөн удирдах зөвлөлийн жилийн үйл ажиллагааны тайланд тусган, банкны жилийн үйл ажиллагааны тайланд нэгтгэн тайлагнадаг. | | |

*Санамж:*

*Компани нь засаглалын зарчмуудыг Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасаа бүртгүүлсэн бүх хуулийн этгээд хэрэгжүүлнэ.*

*Тухайлбал, “МХБ” ХК-ийн 1-р ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь кодексийн зүйл тус бүрээр энэхүү маягтын дагуу хэрэгжилт, эсхүл тайлбарыг бүрэн, 2-р ангилалд бүртгэлтэй этгээд 95 хувийг хангасан байна.*

*Хэрэв дээр дурдсан шалгуурыг хангаагүй буюу хэрэгжүүлээгүй эсвэл тайлбарлаагүй тохиолдолд Тухайн ХК-ийн МХБ-ийн бүртгэлийн ангиллыг бууруулах үндэслэл болох ба нөгөө талаас хөрөнгө оруулагч шийдвэр гаргахад нөлөөлөх шалтгаан болно.*